



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Галт сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/88/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум 2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:  
[erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99900662 Цахим хаяг:  
[tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400 Цахим хаяг:  
[gansukhsa@audit.gov.mn](mailto:gansukhsa@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
Асуудлыг онцолсон хэсэг .....	4
Аудитын гол асуудал.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН ..	6
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
5.1 Төлбөрийн акт .....	17
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж .....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

№ 01/236  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

ГАЛТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
В.ЭРДЭНЭБАЯР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Галт сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Галт сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хантай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Галт сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолын дагуу орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого зохион байгуулах хүрээнд байгууллагын үндсэн хөрөнгийг тоолж баталгаажуулсан байна.

### Аудитын гол асуудал

Галт сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч нь санхүүгийн албаны даргын ажлыг хавсран гүйцэтгэж байгаа, 2022 онд байгууллагын дотоод хяналтын нэгж ажиллаагүйгээс дотоод хяналтын тогтолцоо бүрэн алдагдах эрсдэл үүссэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Галт сумын Засаг даргын Тамгын газар нь 3 хөтөлбөр 9 арга хэмжээг хэрэгжүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 87.0 хувиар үнэлэгдсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>104,487,997.55</b>	<b>115,736,110.30</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>00.00</b>	<b>5,484,454.75</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>00.00</b>	<b>5,484,454.75</b>
3351	Байгууллагаас авах авлага	00.00	5,484,454.75
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>104,487,997.55</b>	<b>110,251,655.55</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>104,487,997.55</b>	<b>110,251,655.55</b>
35410	Бичиг хэргийн материал	3,082,920.00	2,071,020.00
35420	Аж ахуйн материал	35,077,300.35	31,123,000.35
35440	Түлш, шатах тослох материал	00.00	1,200,000.00
35470	Бусад хангамжийн материал	65,613,777.20	75,857,635.20
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,836,050,325.37</b>	<b>4,262,935,961.13</b>
<b>39</b>	<b>Үндсэн хөрөнгө</b>	<b>3,836,050,325.37</b>	<b>4,262,935,961.13</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>3,715,899,397.91</b>	<b>4,110,740,033.54</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,673,036,917.21	3,918,723,629.21
39203	Авто-тээврийн хэрэгсэл	212,421,593.10	307,747,644.10
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	247,481,275.00	389,219,307.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,205,500.00	28,255,500.00
39209	Зам, гүүрийн байгууламж	00.00	9,500,000.00
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	98,000,000.00	98,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	285,627,342.38	358,259,628.38
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>120,150,927.46</b>	<b>152,195,927.59</b>
39301	Програм хангамж	4,350,000.00	13,250,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	116,457,177.45	140,917,177.45
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III+II</b>	<b>3,940,538,322.92</b>	<b>4,378,672,071.43</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>2,941,267.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>2,941,267.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>00.00</b>	<b>2,941,267.00</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>00.00</b>	<b>2,941,267.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	2,941,267.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,940,538,322.92</b>	<b>4,375,730,804.43</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,940,538,322.92</b>	<b>4,375,730,804.43</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,199,154,715.99	1,227,026,715.99
51101	Өмч: - төрийн	1,199,154,715.99	1,227,026,715.99
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,291,692,444.82</b>	<b>1,699,012,926.33</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,291,692,444.82	1,291,692,444.82
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	407,320,481.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,449,691,162.11	1,449,691,162.11
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,940,538,322.92</b>	<b>4,378,672,071.43</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (II)</b>	<b>963,990,562.00</b>	<b>1,159,202,603.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>424,579,297.00</b>	<b>578,300,903.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>424,579,297.00</b>	<b>578,300,903.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	424,579,297.00	578,300,903.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	424,579,297.00	578,300,903.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>539,411,265.00</b>	<b>580,901,700.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,281,165.00</b>	<b>14,705,900.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,300,000.00	00.00

Галт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,757,165.00	5,140,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,224,000.00	9,565,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>529,130,100.00</b>	<b>566,195,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	529,130,100.00	566,195,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>640,269,516.75</b>	<b>731,075,821.49</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>640,269,516.75</b>	<b>672,775,769.49</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>587,644,052.75</b>	<b>648,801,941.82</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>264,083,707.00</b>	<b>277,298,982.00</b>
210101	Үндсэн цалин	260,784,707.00	218,562,871.00
210102	Нэмэгдэл	00.00	32,627,551.00
210104	Урамшуулал	3,299,000.00	22,231,260.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,877,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>35,065,076.00</b>	<b>36,199,042.63</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,721,453.00	25,047,927.68
210202	Тэтгэмжийн даатгал	2,720,679.00	2,908,966.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,119,423.00	2,206,213.55
210204	Ажилгүйдлийн даатгал	493,694.00	546,873.22
210205	Эрүүл мэндийн даатгал	5,009,827.00	5,489,061.21
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,956,169.00</b>	<b>16,298,282.95</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,711,269.00	4,239,282.95
210302	Түлш, халаалт	15,701,900.00	11,814,000.00
210303	Цэвэр, бохир ус	543,000.00	245,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>42,711,440.00</b>	<b>49,518,375.00</b>
210401	Бичиг хэрэг	3,971,600.00	5,106,900.00
210402	Тээвэр, шатахуун	23,945,100.00	32,071,115.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,566,000.00	4,473,500.00
210404	Ном, хэвлэл	178,400.00	2,124,360.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,845,000.00	3,742,500.00
210408	Бараа материал акталсны зардал	4,205,340.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,342,000.00</b>	<b>1,382,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,342,000.00	1,382,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,894,900.00</b>	<b>11,642,450.00</b>
210604	Урсгал засвар	3,894,900.00	11,642,450.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,640,000.00</b>	<b>4,000,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,640,000.00	4,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,871,349.00</b>	<b>20,917,134.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,441,215.00	20,132,429.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	54,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,500.00	51,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	302,184.00	356,705.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>201,079,411.75</b>	<b>231,545,675.24</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,910,100.00	46,380,530.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,083,500.00	10,757,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	153,085,811.75	174,407,445.24
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>52,625,464.00</b>	<b>23,973,827.67</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,044,000.00</b>	<b>3,535,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,206,400.00	00.00

Галт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,337,600.00	3,535,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>22,581,464.00</b>	<b>20,438,827.67</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,581,464.00	20,438,827.67
<b>22</b>	<b>хөрөнгийн зардал</b>	<b>00.00</b>	<b>58,300,052.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>58,300,052.00</b>
221001	Их засвар	00.00	58,300,052.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)+(2)</b>	<b>323,721,045.25</b>	<b>428,126,781.51</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>11,916,000.00</b>	<b>00.00</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	11,916,000.00	00.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,334,500.00</b>	<b>20,806,300.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	234,500.00	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,100,000.00	20,806,300.00
<b>5</b>	<b>ИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>333,302,545.25</b>	<b>407,320,481.51</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>551,427,265.00</b>	<b>580,901,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>100,000.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>100,000.00</b>	<b>00.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>551,327,265.00</b>	<b>580,901,700.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>22,197,165.00</b>	<b>14,705,900.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,300,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,757,165.00	5,140,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,140,000.00	9,565,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>529,130,100.00</b>	<b>566,195,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	529,130,100.00	566,195,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>500,750,665.00</b>	<b>513,092,915.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>500,750,665.00</b>	<b>513,092,915.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>448,125,201.00</b>	<b>489,119,087.33</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>264,081,516.00</b>	<b>278,685,046.38</b>
210101	Үндсэн цалин	260,782,516.00	222,770,439.38
210102	Нэмэгдэл	00.00	30,283,060.00
210104	Урамшуулал	3,299,000.00	21,754,247.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,877,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>35,067,267.00</b>	<b>34,897,433.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,835,855.00	23,694,533.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,625,400.00	2,800,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,100,300.00	2,240,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	493,694.00	560,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,012,018.00	5,601,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,956,169.00</b>	<b>17,498,282.95</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,711,269.00	4,239,282.95
210302	Түлш, халаалт	15,701,900.00	13,014,000.00
210303	Цэвэр, бохир ус	543,000.00	245,000.00

Галт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>38,197,349.00</b>	<b>47,478,095.00</b>
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	4,035,000.00
210402	Тээвэр, шатахуун	20,945,100.00	30,491,335.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,566,000.00	4,473,500.00
210404	Ном, хэвлэл	1,682,300.00	620,460.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,003,949.00	5,857,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>00.00</b>	<b>1,500,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,485,951.00</b>	<b>18,488,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,220,000.00	00.00
210602	Тавилга	390,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,875,951.00	18,488,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,640,000.00</b>	<b>4,000,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,640,000.00	4,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>18,501,349.00</b>	<b>27,003,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,071,215.00	26,219,095.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	54,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,500.00	51,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	302,184.00	356,705.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>66,195,600.00</b>	<b>59,568,230.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,112,100.00	48,810,530.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,083,500.00	10,757,700.00
<b>213</b>	<b>урсгал шилжүүлэг</b>	<b>52,625,464.00</b>	<b>23,973,827.67</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,044,000.00</b>	<b>3,535,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,206,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,337,600.00	3,535,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>22,581,464.00</b>	<b>20,438,827.67</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,581,464.00	20,438,827.67
<b>3</b>	<b>үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (3)-(1)-(2)</b>	<b>50,676,600.00</b>	<b>67,808,785.00</b>
<b>5</b>	<b>хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн (5)</b>	<b>50,676,600.00</b>	<b>67,808,785.00</b>
<b>22</b>	<b>хөрөнгийн зардал</b>	<b>50,676,600.00</b>	<b>67,808,785.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>50,676,600.00</b>	<b>67,808,785.00</b>
221001	Их засвар	00.00	55,358,785.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	50,676,600.00	12,450,000.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,082,697,538.54	7,181,434.20	214,532,266.22	1,304,411,238.96

Галт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,082,697,538.54	7,181,434.20	214,532,266.22	1,304,411,238.96
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,158,030.07	-8,158,030.07
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,199,154,715.99	1,449,691,162.11	1,291,692,444.82	3,940,538,322.92
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,199,154,715.99	1,449,691,162.11	1,291,692,444.82	3,940,538,322.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,199,154,715.99	1,449,691,162.11	1,291,692,444.82	3,940,538,322.92
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	27,872,000.00	00.00	00.00	27,872,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	407,320,481.51	407,320,481.51
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,227,026,715.99	1,449,691,162.11	1,699,012,926.33	4,375,730,804.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төгрөгөөр	Хувиар
2	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	566,195,800.00	545,756,972.33	-20,438,827.67	96.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	506,195,800.00	490,398,187.33	-15,797,612.67	96.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	502,646,200.00	486,863,187.33	-15,783,012.67	96.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	280,076,300.00	274,627,746.38	-5,448,553.62	98.1
210101	Үндсэн цалин	227,507,900.00	222,770,439.38	-4,737,460.62	97.9
210102	Нэмэгдэл	31,516,200.00	30,283,060.00	-1,233,140.00	96.1
210104	Урамшуулал	21,052,200.00	21,574,247.00	522,047.00	102.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,009,600.00	34,589,433.00	-420,167.00	98.8
210201	Тэтгэврийн даатгал	23,806,700.00	23,386,533.00	-420,167.00	98.2
210202	Тэтгэмжийн даатгал	2,800,700.00	2,800,700.00	0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,240,600.00	2,240,600.00	0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	560,100.00	560,100.00	0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,601,500.00	5,601,500.00	0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,599,900.00	16,562,482.95	-2,037,417.05	89.0
210301	Гэрэл, цахилгаан	3,999,900.00	3,303,482.95	-696,417.05	82.6
210302	Түлш, халаалт	14,000,000.00	13,014,000.00	-986,000.00	93.0

Галт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	600,000.00	245,000.00	-355,000.00	40.8
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>42,156,000.00</b>	<b>42,061,495.00</b>	<b>-94,505.00</b>	<b>99.8</b>
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	4,000,000.00	0	100.0
210402	Тээвэр, шатахуун	28,000,000.00	27,995,035.00	-4,965.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,356,000.00	4,356,000.00	0	100.0
210404	Ном, хэвлэл	700,000.00	620,460.00	-79,540.00	88.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,000,000.00	0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,100,000.00	3,090,000.00	-10,000.00	99.7
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>	<b>0</b>	<b>100.0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	0	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>26,950,000.00</b>	<b>26,950,000.00</b>	<b>0</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,400,000.00	9,400,000.00	0	100.0
210602	Тавилга	3,050,000.00	3,050,000.00	0	100.0
210604	Урсгал засвар	14,500,000.00	14,500,000.00	0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,000,000.00</b>	<b>4,000,000.00</b>	<b>0</b>	<b>100.0</b>
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	4,000,000.00	0	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>29,881,500.00</b>	<b>27,003,800.00</b>	<b>-2,877,700.00</b>	<b>90.4</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,953,500.00	26,219,095.00	-2,734,405.00	90.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00	0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	54,500.00	54,500.00	0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,500.00	51,500.00	0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	0	100.0
210807	Газрын төлбөр	500,000.00	356,705.00	-143,295.00	71.3
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>64472900</b>	<b>59568230</b>	<b>-4,904,670.00</b>	<b>92.4</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,703,100.00	48,810,530.00	-4,892,570.00	90.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,769,800.00	10,757,700.00	-12,100.00	99.9
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3549600</b>	<b>3535000</b>	<b>-14,600.00</b>	<b>99.6</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,549,600.00</b>	<b>3,535,000.00</b>	<b>-14,600.00</b>	<b>99.6</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,549,600.00	3,535,000.00	-14,600.00	99.6
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>60,000,000.00</b>	<b>55,358,785.00</b>	<b>-4,641,215.00</b>	<b>92.3</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>60,000,000.00</b>	<b>55,358,785.00</b>	<b>-4,641,215.00</b>	<b>92.3</b>
221001	Их засвар	60,000,000.00	55,358,785.00	-4,641,215.00	92.3
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>566,195,800.00</b>	<b>545,756,972.33</b>	<b>-20,438,827.67</b>	<b>96.4</b>

Галт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>566,195,800.00</b>	<b>545,756,972.33</b>	<b>-20,438,827.67</b>	<b>96.4</b>
132001	Орон нутгийн төсвөөс	566,195,800.00	545,756,972.33	-20,438,827.67	96.4
4	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	0	
5	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0	0	

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>22,197,165.00</b>	<b>14,705,900.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>22,197,165.00</b>	<b>14,705,900.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>22,197,165.00</b>	<b>14,705,900.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,299,000.00</b>	<b>4,057,300.00</b>
210104	Урамшуулал	3,299,000.00	180,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	0	3,877,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>408,051.00</b>	<b>308,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	408,051.00	308,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>0</b>	<b>935,800.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	0	935,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,621,949.00</b>	<b>5,416,600.00</b>
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	35,000.00
210402	Тээвэр, шатахуун	0	2,496,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	210,000.00	117,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,411,949.00	2,767,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>495,000.00</b>	<b>3,988,200.00</b>
210604	Урсгал засвар	495,000.00	3,988,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,457,165.00</b>	<b>00.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,457,165.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,916,000.00</b>	<b>0.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,916,000.00	00.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>22,197,165.00</b>	<b>14,705,900.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>22,197,165.00</b>	<b>14,705,900.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,300,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,757,165.00	5,140,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,140,000.00	9,565,600.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:** Галт сумын ЗДТГ нь тухайн орон нутагт хууль журамд заасан чиг үүрийг орон нутагт хэрэгжүүлэх, ард иргэдийг мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна. 2022 онд "Аймгийн тэргүүний сум болох" гэсэн зорилго тавьж, түүнийгээ биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Иргэдийн хэрэгцээг тодорхойлж, төрийн үйлчилгээг сайжруулах
2. Албан хаагчдын мэдлэг үр чадварыг дээшлүүлж, үр дүнд чиглэсэн байх
3. Үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж шуурхай байдлыг хангах

ЗДТГ-ын дарга нь нь сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, биелэлтийг 87 хувиар дүгнүүлсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:** Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой байгууллагын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг баримталж ажилласан байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн А/38 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэгт ажиллаж байсан ажилтнууд ажлаас гарсан ба 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй байна. Галт сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч нь санхүүгийн албаны даргын ажлыг хавсран гүйцэтгэж байгаа

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Хөвсгөл аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс Галт сумын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд хяналт явуулж, илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Галт сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын

баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсролын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Галт сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 438,133.7 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>			
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	5,484.4	5,484.4
Бараа материал	104,487.9	110,251.8	5,763.7
Үндсэн хөрөнгө	3,836,050.3	4,262,935.9	426,885.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,940,538.3</b>	<b>4,378,672.0</b>	<b>438,133.7</b>
Өр төлбөр	0	2,941.2	2,941.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,940,538.3	4,375,730.8	435,192.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,940,538.3</b>	<b>4,378,672.0</b>	<b>438,133.7</b>

Дээрх хүснэгтээс харахад авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс өмнөх оноос нэмэгдсэн байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлгүй байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 5,763.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд ухаалаг 2 худаг шинээр ашиглалтад орсонтой холбоотой түлээ, хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэн нь гол нөлөөг үзүүлсэн байна.
3. Үндсэн хөрөнгө данс 426,885.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд орон нутгийн хөгжлийн сангаас 184,719.0 мянган төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 205,189.0 мянган төгрөг, аймгийн хөрөнгө оруулалтаар 165,855.1 мянган төгрөг, иргэдийн хандиваар 8,620.0 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 12,450.0 мянган төгрөг, 2 газар 27,872.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, онцгой байдлын газарт 3,412.0 мянган төгрөгийн газрыг данснаас хасаж шилжүүлсэн, хөрөнгийн элэгдэл 174,407.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 464,209.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх дүнг 5,401.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 469,610.5 мянган төгрөгөөр баталсан байна. Орон нутгийн төсвөөс авах дүн

нэмэгдсэн нь цалингийн үр дүнгийн урамшуулал болон байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой.

Байгууллагын 2022 оны төсвийг сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны 04 тоот тогтоолоор баталсан ба ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоолоор 96,585.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 566,195.8 мянган орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 566,195.8 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 20,438.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 545,757.0 мянган төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 5,448.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,037.4 мянган төгрөг, засварын зардлаас 4,641.2 мянган төгрөг бараа үйлчилгээний зардлын төсвийг 4,904.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	482,642.3	469,555.6	13,086.7	97.4
2	Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	60,000.0	55,358.8	4,641.2	92.3
3	Байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх	23,553.5	20,842.6	2,710.9	88.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар тендерийн орлого 315.0 мянган төгрөг, спорт заал, ухаалаг худгийн орлого 9,250.6 мянган төгрөг, статистикийн хэлтсээс мал тооллогын зардал 4,796.8 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас хамтарсан багийн үйл ажиллагааны зардалд 300.0 мянган төгрөг, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 43.5 мянган төгрөг нийт 14,705.9 мянган төгрөгийн орлого орсон.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Галт сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор С.Гансүх гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Галт сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 640,269.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 12,805.4 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль *хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэрэгүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт*, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Галт сумын ЗДТГ-ын 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянахад 2022 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 151 мэдээлэл оруулахаас 2 мэдээлэл хугацаа хоцроож, 147 мэдээлэл хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан

бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Галт сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хянаж үзэхэд зөвлөмжийн хэрэгжилтийг биелүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	1,500.0	1	1,500.0	100
Зөвлөмж	1	1,400.0	1	1,400.0	100
Нийт дүн	2	2,900.0	2	2,900.0	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Галт сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч нь санхүүгийн албаны даргын ажлыг хавсран гүйцэтгэж байгаа, 2022 онд байгууллагын дотоод хяналтын нэгж ажиллаагүйгээс дотоод хяналтын тогтолцоо бүрэн алдагдах эрсдэл үүссэн байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,886.1 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэн Аудитаар дотоод хяналт, зардлын эдийн засгийн ангилал зөрчсөнтэй холбоотой 2,886.1 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

#### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Зардлын данстай холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Галт сумын Засаг даргын Тамгын газар нь Тайлант онд 1,386.1 мянган төгрөгийн НДШ-ийн зардал, 1,500.0 мянган төгрөгийн нэг удаагийн шагнал, урамшууллыг цалингийн зардлаас бүлэг хооронд зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг мөрдөж ажиллах

## 2. Дотоод хяналттай холбоотой асуудал

### Илрүүлэлт:

Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын нэгжийн бүрэлдэхүүнд байсан ажилтнууд ажлаас гарсан, 2022 онд дотоод хяналт хэрэгжээгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтын нэгжийг шинээр байгуулан жил бүр дотоод хяналтын нэгжийн ажлын төлөвлөгөө боловсруулж, түүний хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Галт сумын Засаг даргын Тамгын газар нь НДШ-ийн зардал, нэг удаагийн шагнал, урамшууллыг цалингийн зардлаас зарцуулсан байна.	1	2,886.1					1	2,886.1				
Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын нэгжийн бүрэлдэхүүнд байсан ажилтнууд ажлаас гарсан, 2022 онд дотоод хяналт хэрэгжээгүй байна.	1						1					
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2,886.1</b>					<b>2</b>	<b>2,886.1</b>				